



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ҮНДЭСНИЙ УРЛАГИЙН ИХ ТЕАТРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/201/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261628 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: П.Амарсанаа
Утас: 261628 Цахим хаяг: amarsanaap@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Ихэрмөрөн-Аудит" ХХК
Захирал Б.Мядагмаа
Утас: 99389208 Цахим хаяг: ikhurmurun.audit@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа	16
4.2 Албан шаардлага	16
4.3 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХГ	Аудитын хоёрдугаар газар
НА	Нотлох ажил
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
УРЛАГИЙН ИХ ТЕАТРЫН ЗАХИРАЛ
Г.ЦОГГЭРЭЛ ТАНАА

2022.02.25 № 07/433
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улсын Үндэсний урлагийн их театр 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Улсын Үндэсний урлагийн их театр 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,458,777,812.35	1,628,090,689.75
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	40,494.75	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	40,494.75	-
31110	Төгрөг	40,494.75	
33	АВЛАГА	3,615,529.62	32,202,428.40
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	62,991.52	409,890.30
335	Бусад авлага	3,552,538.10	31,792,538.10
3351	Байгууллагаас авах авлага	-	13,400,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	3,552,538.10	18,392,538.10
35	БАРАА МАТЕРИАЛ	1,455,121,787.98	1,595,888,261.35
351	Түүхий эд материал	1,208,543,248.99	1,446,667,310.34
35110	Тусгай зориулалттай материал	1,208,543,248.99	1,442,409,935.34
35300	Бэлэн бүтээгдэхүүн	3,910,375.00	4,257,375.00
354	Хангамжийн материал	242,668,163.99	149,220,951.01
35410	Бичиг хэргийн материал	-	2,708,070.00
35420	Аж ахуйн материал	238,198,163.99	144,572,881.01
35440	Түлш, шатах тослох материал	4,470,000.00	1,940,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,407,876,531.20	1,591,749,985.91
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,407,876,531.20	1,591,749,985.91
392	Биет хөрөнгө	444,647,151.20	627,557,064.28
39203	Авто-тээврийн хэрэгсэл	483,347,827.25	457,053,729.62
39204	Хуримтлагдсан элэгдэл	(236,703,507.77)	(209,952,978.46)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	311,508,117.43	199,414,861.11
39206	Хуримтлагдсан элэгдэл	(252,149,945.14)	(98,028,486.87)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	223,501,168.95	129,039,403.29
39208	Хуримтлагдсан элэгдэл	(168,599,134.54)	(55,626,480.56)
39214	Бусад үндсэн хөрөнгө	640,241,180.53	401,483,072.19
39215	Хуримтлагдсан элэгдэл	(556,498,555.51)	(195,826,056.04)
393	Биет бус хөрөнгө	963,229,380.00	964,192,921.63
39301	Програм хангамж	1,488,750.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,488,750.00)	(286,458.37)
39303	Бусад биет бус хөрөнгө	963,229,380.00	963,229,380.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,866,654,343.55	3,219,840,675.66
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	108,272.00	206,933.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	108,272.00	206,933.00
413	Өглөг	108,272.00	206,933.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	206,933.00
4136	Бусад өглөг	108,272.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	108,272.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,866,546,071.55	3,219,633,742.66
51	Засгийн газрын хувь оролцоо	2,866,546,071.55	3,219,633,742.66
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,564,230,035.43	1,564,230,035.43
51101	Өмч: - төрийн	1,564,230,035.43	1,564,230,035.43
512	Хуримтлагдсан үр дүн	1,276,212,239.12	1,639,915,757.23
51210	Өмнөх үеийн үр дүн	1,276,212,239.12	1,286,828,086.12
51220	Тайлант үеийн үр дүн	-	353,087,671.11
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	26,103,797.00	15,487,950.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,866,654,343.55	3,219,840,675.66

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,408,630,142.00	3,644,423,954.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	270,000,000.00	317,523,190.70
120	Нийтлэг татварын бус орлого	270,000,000.00	317,523,190.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	270,000,000.00	317,523,190.70
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	175,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	270,000,000.00	317,348,190.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,138,630,142.00	3,326,900,764.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,100,781,792.00	3,013,517,364.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,100,781,792.00	3,013,517,364.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	37,848,350.00	313,383,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	282,900,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	37,848,350.00	30,483,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,245,308,130.92	3,291,336,283.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,245,308,130.92	3,291,336,283.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,135,677,378.96	3,208,635,254.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,503,705,755.82	2,457,364,992.33
210101	Үндсэн цалин	1,755,266,543.22	1,747,078,677.33
210102	Нэмэгдэл	633,602,812.60	432,520,616.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	114,836,400.00	277,765,698.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	312,428,061.22	321,943,875.29
210201	Тэтгэврийн даатгал	232,120,456.23	218,917,265.36
210202	Тэтгэмжийн даатгал	24,823,499.09	20,605,342.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,858,799.68	26,127,106.85
210204	Ажилгүйдлийн даатгал	4,964,799.41	5,117,559.31
210205	Эрүүл мэндийн даатгал	30,660,506.81	51,176,601.69
2104	Хангамж, бараа материалын зардал	61,038,189.41	28,987,633.34
210401	Бичиг хэрэг	1,682,027.60	2,115,230.00
210402	Тээвэр, шатахуун	4,030,000.00	2,990,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	632,300.00	658,999.61
210404	Ном, хэвлэл	403,700.00	65,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,083,039.25	17,161,950.08
210408	Бараа материал акалсны зардал	49,207,122.56	5,995,853.65
2105	Нормативт зардал	0.00	3,539,524.75
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	3,539,524.75
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,999,640.00	-
210604	Урсгал засвар	1,999,640.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	125,065,643.57	237,404,602.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	116,600,710.57	230,476,542.90
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,435,200.00	4,400,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	594,972.00	319,430.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	481,600.00	481,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	227,820.00	83,130.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	550,000.00	0.00
210807	Газрын төлбөр	2,175,341.00	1,643,900.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	131,440,088.94	159,394,625.99
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	131,440,088.94	159,394,625.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	109,630,751.96	82,701,028.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	105,490,220.00	46,285,964.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	79,030,220.00	24,985,964.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,460,000.00	21,300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,140,531.96	36,415,064.99
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,140,531.96	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	36,415,064.99
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	163,322,011.08	353,087,671.11
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	163,322,011.08	353,087,671.11

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	601,000,655.43	26,103,797.00	1,112,890,228.04	1,739,994,680.47
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	601,000,655.43	26,103,797.00	1,112,890,228.04	1,739,994,680.47
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	963,229,380.00	-	-	963,229,380.00
Тайлант үеийн үр дүн	-	-	163,322,011.08	163,322,011.08
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,564,230,035.43	26,103,797.00	1,276,212,239.12	2,866,546,071.55
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	10,615,847.00	10,615,847.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,564,230,035.43	26,103,797.00	1,286,828,086.12	2,877,161,918.55
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(10,615,847.00)	-	(10,615,847.00)
Тайлант үеийн үр дүн	-	-	353,087,671.11	353,087,671.11
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,564,230,035.43	15,487,950.00	1,639,915,757.23	3,219,633,742.66

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,138,630,142.00	3,327,075,764.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	175,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	175,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	175,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	175,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,138,630,142.00	3,326,900,764.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,100,781,792.00	3,013,517,364.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,100,781,792.00	3,013,517,364.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	37,848,350.00	313,383,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс	-	282,900,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	37,848,350.00	30,483,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,136,989,647.25	3,300,461,368.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,136,989,647.25	3,300,461,368.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,027,358,895.29	3,217,760,339.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,482,356,472.60	2,457,613,230.11
210101	Үндсэн цалин	1,733,917,260.00	1,747,326,915.11
210102	Нэмэгдэл	633,602,812.60	432,520,616.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	114,836,400.00	277,765,698.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	331,414,653.59	321,943,875.29
210201	Тэтгэврийн даатгал	232,120,456.23	218,917,265.36
210202	Тэтгэмжийн даатгал	24,823,499.09	20,605,342.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,858,799.68	26,127,106.85
210204	Ажилгүйдлийн даатгал	4,964,799.41	5,117,559.31
210205	Эрүүл мэндийн даатгал	49,647,099.18	51,176,601.69
2104	Хангамж, бараа материалын зардал	9,710,317.00	4,589,533.61
210401	Бичиг хэрэг	581,617.00	1,131,200.00
210402	Тээвэр, шатахуун	3,665,800.00	460,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,258,800.00	658,999.61
210404	Ном, хэвлэл	403,700.00	65,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,800,400.00	2,273,734.00
2105	Нормативт зардал	435,900.00	637,814.75
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	435,900.00	637,814.75
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	201,441,552.00	431,475,886.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	191,651,619.00	424,527,826.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,435,200.00	4,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	594,972.00	319,430.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	481,600.00	481,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	227,820.00	83,130.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	550,000.00	0.00
210807	Газрын төлбөр	3,175,341.00	1,643,900.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	325,000.00	420,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	109,630,751.96	82,701,028.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	105,490,220.00	46,285,964.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	79,030,220.00	24,985,964.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,460,000.00	21,300,000.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,140,531.96	36,415,064.99
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,140,531.96	36,415,064.99
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,640,494.75	26,614,395.25
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,600,000.00	26,654,890.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,600,000.00	26,654,890.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,600,000.00	26,654,890.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,600,000.00	26,654,890.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,600,000.00)	(26,654,890.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	40,494.75	(40,494.75)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		40,494.75
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	40,494.75	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,019,253,100.00	2,977,142,793.76	42,110,306.24	98.6
УРСГАЛ ЗАРДАЛ	3,019,253,100.00	2,977,142,793.76	42,110,306.24	98.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,988,203,400.00	2,951,856,829.76	36,346,570.24	98.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,480,712,400.00	2,457,613,230.11	23,099,169.89	99.1
Үндсэн цалин	1,757,229,100.00	1,747,326,915.11	9,902,184.89	99.4
Нэмэгдэл	607,116,500.00	432,520,616.25	174,595,883.75	71.2
Унаа хоолны хөнгөлөлт	116,366,800.00	277,765,698.75	(161,398,898.75)	238.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	335,118,100.00	321,943,875.29	13,174,224.71	96.1
Тэтгэврийн даатгал	235,823,800.00	218,917,265.36	16,906,534.64	92.8
Тэтгэмжийн даатгал	24,823,600.00	20,605,342.08	4,218,257.92	83.0
ҮОМШӨ-ний даатгал	19,858,900.00	26,127,106.85	(6,268,206.85)	131.6
Ажилгүйдлийн даатгал	4,964,700.00	5,117,559.31	(152,859.31)	103.1
Эрүүл мэндийн даатгал	49,647,100.00	51,176,601.69	(1,529,501.69)	103.1
Хангамж, бараа материалын зардал	4,414,600.00	4,414,533.61	66.39	100.0
Бичиг хэрэг	497,600.00	956,200.00	(458,600.00)	192.2
Тээвэр, шатахуун	484,100.00	460,000.00	24,100.00	95.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,949,400.00	658,999.61	1,290,400.39	33.8
Ном, хэвлэл	373,000.00	65,600.00	307,400.00	17.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,110,500.00	2,273,734.00	(1,163,234.00)	204.8

Нормативт зардал	377,500.00	373,814.75	3,685.25	99.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	377,500.00	373,814.75	3,685.25	99.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	167,580,800.00	167,511,376.00	69,424.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	160,436,200.00	160,433,316.00	2,884.00	100.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	4,000,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	337,100.00	319,430.00	17,670.00	94.8
Тээврийн хэрэгслийн татвар	481,600.00	481,600.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	83,130.00	48,870.00	63.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	550,000.00	550,000.00	-	100.0
Газрын төлбөр	1,643,900.00	1,643,900.00	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,049,700.00	25,285,964.00	5,763,736.00	81.4
Бусад урсгал шилжүүлэг	31,049,700.00	25,285,964.00	5,763,736.00	81.4
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,721,700.00	24,985,964.00	5,735,736.00	81.3
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	328,000.00	300,000.00	28,000.00	91.5
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,019,253,100.00	2,977,102,299.01	42,150,800.99	98.6
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,019,253,100.00	2,977,102,299.01	42,150,800.99	98.6
Улсын төсвөөс санхүүжих	3,019,253,100.00	2,977,102,299.01	42,150,800.99	98.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	40,494.75		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-		
АЖИЛЛАГСАДЫН ТОО	189	189	-	100
Удирдах ажилтан	1	1	-	100
Гүйцэтгэх ажилтан	175	175	-	100
Үйлчлэх ажилтан	13	13	-	100

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	313,383,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	313,383,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	292,383,400.00
2105	Нормативт зардал	-	264,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	264,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,500,000.00
210604	Урсгал засвар	-	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	290,619,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	290,199,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	420,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	21,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	21,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	21,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	313,383,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	313,383,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	282,900,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	30,483,400.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Үндэсний урлагийн их театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн мэдээллийг нийгмийн даатгал, татварын цахим системд үнэн зөв мэдээлэхтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 18-ны хооронд Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн аудитор Ц.Мөнхтуяа, ахлах аудитор Д.Оюундаваа нар гүйцэтгэж, хяналтыг захирал Б.Мядагмаа хэрэгжүүлсэн.

Үндэсний урлагийн их театр 2021 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Үндэсний урлагийн их театр нь үндэсний урлагаа хөгжүүлэх, сурталчлан таниулах, уран бүтээл туурвиж, соёл урлагийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг, Соёлын яамны харьяа байгууллага юм.

Тус театр нь 2021 онд Монгол өв соёл, ардын урлагийг өвлүүлэх, уламжлан хөгжүүлэх, сурталчлан таниулах зорилгоор “Монгол угсаатны билиг” тайзны бүрэн хэмжээний тоглолт, төв халхын чуулбар бүжгийн “Хан тэнгэр халх товчоо мину” концертыг шинээр бүтээх ажлыг эхлүүлэн туурвиж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд орсон дараах өөрчлөлт байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол;
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр “Босго үнэ шинэчлэх тухай” тогтоол;
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр “Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай” тушаалын хавсралт “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Соёлын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод хяналтын газраас тус театрын 2020 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, дотоод аудитыг хийж "сайжруулах шаардлагатай" гэсэн дүгнэлт өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Үндэсний урлагийн их театр 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг төсвийн тухай хуулийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн дагуу иж бүрэн бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,245,308.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 48,679.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Үндэсний урлагийн их театрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 353,186.4 мянган төгрөгөөр буюу 12.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	40.5	-	(40.5)
Авлага	3,615.5	32,202.4	28,586.9
Бараа материал	1,455,121.8	1,595,888.3	140,766.5
Үндсэн хөрөнгө	1,407,876.5	1,591,750.0	183,873.5
Нийт хөрөнгө	2,866,654.3	3,219,840.7	353,186.4
Богино хугацаат өр төлбөр	108.3	206.9	98.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,866,546.1	3,219,633.7	353,087.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,866,654.3	3,219,840.7	353,186.4

Авлага дансны 32,202.4 мянган төгрөгийн үлдэгдэлд ажиллагсадтай холбоотой 409.9 мянга, байгууллагаас авах авлага 13,400.0 мянга, хувь хүмүүсээс авах авлага 18,392.5 мянган төгрөг байгаа нь 2021 онд шинээр хийхээр төлөвлөсөн 2 концертын гутал, хувцас, тайзны материал, жижиг хэрэгсэлд орох бараа материалын олдоц зах зээлд

муудаж, үнэ өссөж байгаагаас шалтгаалан гэрээний гүйцэтгэл бүрэн хангагдаагүйтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,595,888.3 мянган төгрөг болж, 140,766.5 мянган төгрөгөөр өссөн нь шинэ уран бүтээл хийхтэй холбоотой тоглолтын гутал хувцас, жижиг хэрэгсэл худалдаж авсанаас шалтгаалсан ба бараа материалын дансны нийт үлдэгдлийн 90.3 хувь буюу 1,442,409.9 мянган төгрөгийг энэ төрлийн бараа материалын үлдэгдэл эзэлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,591,750.0 мянган төгрөг болж, 183,873.5 мянган төгрөгөөр өсөхөд дараах ажил гүйлгээ нөлөөлсөн байна.Үүнд:

- ТӨБЗГ-ын 2021 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 164 дүгээр тогтоолоор “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 26,837.5 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй Соната-8 суудлын автомашиныг балансаас балансад шилжүүлж авсан.
- ТӨБЗГ-ын 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 282 дугаар тогтоолоор Үндэсний урлагийн их театрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой 439 нэр төрлийн 794,757.1 мянган төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, 288,121.7 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- ТӨБЗГ-ын 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 296 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 44 нэрийн 20,356.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данснаас хассан.
- 26,654.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдаж авсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,219,633.7 мянган төгрөг болж, 353,087.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Үндэсний урлагийн их театрын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого өмнөх оноос 235,793.8 мянган төгрөгөөр буюу 6.9 хувиар өсч, өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээж авсан орлого, урсгал үйл ажиллагааны санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн орлого байна.

Орлогын дансны материаллаг өөрчлөлт нь тус байгууллагын 2021 оны төсөв өмнөх оноос 87,264.4 мянган төгрөгөөр буурч батлагдсан, нэмэлт төсвийн дансаар тайзны бүрэн хэмжээний тоглолтын санхүүжилт 270,000.0 мянган төгрөгийг Соёлын яамнаас хүлээж авсан, ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоосон үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй орлого хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой.

Нийт зардал өмнөх оноос 46,028.2 мянган төгрөгөөр буюу 1.4 хувиар өссөн нь хангамж бараа материалын зардал 32,050.6 мянга, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардал 54,044.2 мянга төгрөгөөр буурч, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 112,338.9 мянган төгрөгөөр өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,765,469.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3,765,469.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 713,462.0 мянган төгрөгөөр бууруулж 3,052,007.5 мянган төгрөгөөр баталсан бөгөөд төсвийн жилийн явцад хийсэн

тодотголоор төсвийн зардал болон санхүүжүүлэх эх үүсвэрийг 32,754.4 мянган төгрөгөөр бууруулж, 3,019,253.1 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,019,253.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 3,013,517.4 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлж, 5,735.7 мянган төгрөгийг дутуу санхүүжүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,013,517.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 2,977,142.8 мянган төгрөгийг зарцуулж, 36,415.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,977,142.8 мянган төгрөг буюу 98.6 хувьтай байгаа нь цалин, шимтгэлийн зардлыг 36,273.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг хөтөлбөр, арга хэмжээгээр авч үзэхэд соёл урлаг хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардал арга хэмжээ 36,346.5 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал арга хэмжээ 5,763.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71805	Соёл урлаг	3,019,253.1	2,977,142.8	42,110.3	98.6
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,829,130.7	2,792,784.2	36,346.5	98.7
1.2	80214	Уран бүтээлийн зардал	159,072.7	159,072.7	0.0	100.0
1.3	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	31,049.7	25,285.9	5,763.8	81.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндэсний урлагийн их театр нь 2021 онд нэмэлт төсвийн дансаар Соёлын сайдын 2021 оны А/50 дугаар тушаалаар “Монгол угсаатны билиг” тайзны бүрэн хэмжээний уран бүтээл хийх санхүүжилт 270,000.0 мянган төгрөг, Соёлын сайдын 2021 оны А/279 дүгээр тушаалаар уран бүтээл туурвих дэмжлэг 12,900.0 мянган төгрөгийг тус тус хүлээн авсан ба төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон тоглолтын орлого 30,483.4 мянган төгрөг, нийт 313,383.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс уран бүтээлийн зардалд 290,199.4 мянган төгрөг, ажиллагсдад урамшуулал олгох, эх үүсвэр дутагдалтай урсгал үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд 23,184.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд төслийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээний хэрэгжилт 98.6 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 98.6 хувийн биелэлттэй байна.

Тус театрын төсвийн захирагчийн хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн гол үзүүлэлт нь уран бүтээлийн тоо, үзэгчийн тоо бөгөөд цар тахлын улмаас олон нийтэд зориулсан үзвэр үйлчилгээг зогсоосон байсныг Улсын онцгой комиссын шийдвэрээр 2021 оны 9 дүгээр сараас 50 хувийн дүүргэлттэйгээр эхлүүлж, нийт 495 үзэгч үзсэн байна.

Түүнчлэн цар тахлын нөхцөл байдлын улмаас материалын олдоц, үнийн өсөлтөөс шалтгаалан тус театрын тайзны бүрэн хэмжээний тоглолт дэглэж, олон нийтийн хүртээл болгох төлөвлөгөөт ажлын гүйцэтгэл он дамжиж, дараагийн жилд үргэлжлэхээр болсон байна.

3.8 Аудитын гол асуудал

Үндэсний урлагийн их театрын захирлын 2021 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн А/49 дүгээр тушаалаар байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн боловсруулж, баталсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2021 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн А/108 дугаар тушаалаар батлагдсан шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэлийг баримтлан шалгадагч байгууллагын шилэн дансны мэдээллийг шалгахад байршуулбал зохих мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилтийг хангасан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 40,378.2 мянган төгрөгийн 9 алдаа зөрчил илрүүлж, илэрсэн алдааг залруулах талаар зөвлөмж өгсөн.

Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянаж үзэхэд зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4,470.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага, 24,516.6 мянган төгрөгийн 5 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага	3	4,470.0	3	4,470.0	-	-	100.0
Зөвлөмж	5	24,516.6	5	24,156.6	-	-	100.0
Нийт дүн	8	28,986.6	8	28,986.6	-	-	100.0

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар 2021 онд туурвисан “Монгол угсаатны билиг”, “Төв халх бүжгийн чуулбар” тоглолттой холбоотой гарсан зардлын гүйцэтгэлд анхаарах шаардлагатай гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 152,116.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 119,319.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 28,240.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 4,557.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 32,797.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшин 48,679.6 мянган төгрөгөөс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай холбоотой дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- “Төв халхын бүжгийн чуулбар” бүжгийн концертын уран бүтээлийн ажлыг гарсан гүйцэтгэлийн дүнг тооцолгүйгээр бүхэлд нь авлагаар бүртгэсэн байсныг гүйцэтгэлийн баримтуудад үндэслэн 75,160.0 мянган төгрөгөөр авлага бууруулах залруулга хийсэн.
- “Монгол угсаатны билиг” тайзны бүрэн хэмжээний концертын уран бүтээлд шаардагдах бараа, материалын үнийг гүйцэтгэгч нарт шилжүүлсэн боловч цар тахлын нөхцөл байдлын улмаас бараа, материал хил дээр гацсан, барааны нийлүүлэлт муудаж, олдоц муудсан, үнэ өссөн шалтгаанаар гэрээний хугацаанд хүлээж аваагүй авлагаар бүртгэсэн боловч он гарангуут нийлүүлэгдсэн тул УСНББОУС-14 “Тайлангийн өдрийн дараах үйл явц” стандартын 10 дугаар параграфт “Байгууллага нь тайлангийн өдрийн дараах залруулагдах үйл явдлыг тусгахын тулд өөрийн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дүнгээ залруулна” гэж заасныг үндэслэн 44,159.5 мянган төгрөгийг залруулга хийж, авлагыг бууруулсан.

4.2 Албан шаардлага

Үндэсний урлагийн их театр нь 2021 онд шинээр бүтээх концертын уран бүтээлд нийлүүлэх бараа, материалын санхүүжилтийг гүйцэтгэлд нь үндэслэж олгоогүй, 100 хувь урьдчилан төсвөөс 28,240.0 мянган төгрөгийг шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41

дүгээр зүйлийн 41.2.6-д “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх;” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх;

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. *Цахим мэдээллийн системтэй холбоотой асуудал*

1.1. *Илрүүлэлт:*

Нийгмийн даатгалын цахим системийн мэдээллийг нягтлан бодох бүртгэлийн журналын бичилттэй тулгахад нийт шимтгэлийн дүн, ажил олгогчийн шимтгэлийн дүнгүүд 4,557.3 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 заалтын “үнэн зөв байх” зарчимтай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. *Өгсөн зөвлөмж:*

Нягтлан бодох бүртгэлийн мэдээллийг Нийгмийн даатгал, татварын цахим системд үнэн зөв мэдээлж байх, түүнд тавих хяналтыг сайжруулж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

5. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулгын товч утга	Нийт алдаа зөрчил		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	Үндэсний урлагийн их театр	АХГ-2022/201/НА-СТА-ТШЗ	Төв халхын бүжгийн чуулбар концертын уран бүтээлийн ажилд гүйцэтгэл гарсан байхад бүтнээр нь авлагаар бүртгэсэн.	Гүйцэтгэл гарсан хэмжээгээр авлагыг бууруулж бүртгэсэн.	1	75,160.0	1	75,160.0						
2	Үндэсний урлагийн их театр	АХГ-2022/201/НА-СТА-ТШЗ	Тоглолтын гутал, хувцас, жижиг хэрэглэл худалдаж авахаар мөнгө шилжүүлж, авлагаар бүртгэсэн.	УСНББОУС-14 "Тайлангийн өдрийн дараах үйл явц" стандартын дагуу залруулга хийв.	1	44,159.5	1	44,159.5						
3	Үндэсний урлагийн их театр	АХГ-2022/201/НА-СТА-ТШЗ	Нийгмийн даатгалын цахим системийн мэдээллийг нягтлан бодох бүртгэлийн журналын бичилттэй тулгахад нийт шимтгэлийн дүн, ажил олгогчийн шимтгэлийн дүнгүүд зөрүүтэй байна.	Нягтлан бодох бүртгэлийн мэдээллийг Нийгмийн даатгал, татварын цахим системд үнэн зөв мэдээлж байх, түүнд тавих хяналтыг сайжруулж ажиллах;	1	4,557.3							1	4,557.3
4	Үндэсний урлагийн их театр	АХГ-2022/201/НА-СТА-ТШЗ	Бараа, материалын үнийг гүйцэтгэлд үндэслэн олгоогүй, 100 хувь урьдчилан олгосон байна	Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа гүйцэтгэлд үндэслэн гэрээ, төлбөрийн хуваарийн дагуу санхүүжилтийг олгож байх	1	28,240.0					1	28,240.0		
	ДҮН				4	152,116.8	2	119,319.5			1	28,240.0	1	4,557.3
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал														
	ДҮН													
НИЙТ ДҮН					4	152,116.8	2	119,319.5	0	0	1	28,240.0	1	4,557.3

[illegible]